



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 205

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Боловсролын үнэлгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй болсон, хоёр удаагийн нээлттэй дуудлагын худалдаагаар оролцогч ирээгүй, 23,818,425.00 (хорин гурван сая найман зуун авсан найман мянга дөрвөн зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины нээлттэй дуудлагын худалдааг (3 дахь) дахин зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баярсайхан, Боловсролын үнэлгээний төвийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Ган-Эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих захиргааны актын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД

Төрийн чөмчийн бодлого, зохицуулалтын
газарын 2019 оны 05 дугаар сарын 25.-ны
өдрийн 25 дугаар тогтоолын хавсралт



Боловсролын үнэлгээний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нээлттэй
дуудлагын худалдаагаар худалдах автомашини жагсаалт

Д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хурумтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Төбзг-ын 2016 оны 273 дугаар тогтоолoor тогтоосон доод үнэ	Худалдах доод үнийн санал
1	Санта-Фэ, УБИ 41-38, арал: суудлын, КМНISH81DP7U164772	2007/2011	14,320	23,818,425	23,818,425	-	7,000,000	3,500,000
				23,818,425	23,818,425	-		3,500,000
					(хорин гурван сая найман зуун арван найман мянга дөрвөн зуун хорин таван)		(долоон сая)	(гурван сая таван зуун мянган)
					Нийт дүн			